**МОНГОЛ УЛС**
**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

20 20 оны 08 сарын 26 өдөр Дугаар А/482 Алтай хот

## Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”, “Дүрэм шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн хөрөнгө оруулалтаар Шарга сумд шинэ худгийн барилга барьж, ухаалаг төхөөрөмж суурилуулах, хайс хамгаалалт хийсэн ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Б.Бямбадорж -Газрын харилцаа, барилга хот байгуулалтын байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Г.Бат-Эрдэнэ -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд:
- М.Мандаххүү -Архивын тасгийн дарга
- М.Эрдэнэбилэг -Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн хөтөлбөрийн орон нутгийн зөвлөх
- Л.Балдорж -Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
- Т.Оргилсайхан -Хүйсийн говь цэцэг нуурын сав газрын ахлах мэргэжилтэн
- Д.Байгальмаа -“Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
- М.Тунгалагтамир-Шарга сумын Засаг дарга
- Д.Даваадорж -“Ус-Алтай” ХХК-ийн инженер

2. Барилга, байгууламж, тохижилтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, ажлын тоо хэмжээтэй нийцүүлэх, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын сайтад байршуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3. Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг хүлээж авсан акт, баримт бичгийг үндэслэн хөрөнгийг бүртгэж, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, байгууламжийн урсгал засвар, үйл ажиллагааны зардлыг төсөвт тусгах, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг Шарга сумын Засаг даргын Тамгын газар (Р.Оюунчимэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ГАНБАТ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

0201001206